

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР**



**ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН  
2015 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**  
Аудитын код: УАГ-САГ/2016/27/СТА-ТЕЗ

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:**

УАГ-ын Санхүүгийн аудитын газрын дарга С.Энхзаяа  
Утас: 261663  
Цахим хаяг: [enkhzayas@audit.gov.mn](mailto:enkhzayas@audit.gov.mn)

Аудитын менежер: Ч.Болд  
Утас: 261885  
Цахим хаяг: [boldch@audit.gov.mn](mailto:boldch@audit.gov.mn)

Аудитор: Р.Цолмон  
Утас: 261628  
Цахим хаяг: [tsolmonr@audit.gov.mn](mailto:tsolmonr@audit.gov.mn)

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу 3  
Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар 15160  
Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.25 № 710  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Аудитын гэрчилгээ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

#### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

1. Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч нь төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Үндэсний аудитын газарт 2016 оны 4 дүгээр сарын 05-нд 1а/1388 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Тус санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг нэгтгээгүй нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх

\\10.10.10.20\Bichig\_Kheregl\Yawsan\_Bichig\2016\0425SAG111.Docx

073859

журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-д "...төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн тайлагналын зорилгоор хяналтанд байгаа төсөвт байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн санхүүгийн нэгтгэсэн тайланг толилуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч нь 2015 оны санхүүгийн нэгтгэсэн залруулсан тайланг 2016 оны 4 дүгээр сарын 21-ний 1а/1682 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт дахин ирүүлсэн. Тус санхүүгийн нэгтгэсэн залруулсан тайлан нь өмнөх хуулийн хугацаанд ирүүлсэн тайлангаас санхүүгийн байдлын тайлан нь нийт 64,072.8 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь материаллаг байдлын тогтоосон түвшингөөс 53,557.9 сая төгрөгөөр илүү байна.

2. Залруулсан санхүүгийн нэгтгэсэн тайланд гадаад зээлийн болон тусламжийн дансдын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн тодруулгад бүрэн тусгаагүй нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын 4.2.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардлын зүйлсийг тохируулсны дараа нэгтгэсэн дүнг гарган тайлагнана", мөн журмын 4.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын хооронд хийгдсэн устгагдсан ажил, гүйлгээг маягт 1-ийн 1.1, 1.2-ын дагуу баталгаажуулан санхүүгийн тайланд хавсарган ирүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Засгийн газрын нөөц хөрөнгийн дүн, улсын төсвөөс авсан санхүүжилтийн буцаан төвлөрүүлэлтийн дүнг тус тус зөрүүтэй тайлагнасан нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт 1-ийн хавсралт А-д "Үнэн зөв", "Иж бүрэн", "Тохиолдсон байх", "Үнэлгээ" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар илрүүлсэн дээрх зөрчлүүд нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт 1, Аудитын Олон Улсын стандарт 505, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

#### **Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



АЗАНГАД

\\10.10.10.20\Bichig\_Kherel\Yawsan\_Bichig\2016\0425SAG111.Docx

## Аудитын тайлан

### Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан ҮАГ-САГ/2015/27-СТА-ТЕЗ-д аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрүүл мэнд, спортын яамны удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 05-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 4 дүгээр сарын 05-наас 2016 оны 4 дүгээр сарын 22-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын Орон нутгийн аудитын албаны аудитор Р.Цолмон хэрэгжүүлэв.

Үндэсний аудитын газар аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж, аудитын тайланг 2016 оны 4 дүгээр сарын 25-нд Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгчид гардуулна.

### Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэнд, спортын яамны удирдлага нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль болон бусад хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд: “Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ” гэж эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог тодорхойлсон байна.

Мөн шударга өрсөлдөөн, сонголтонд суурилсан, аюулгүй, чанартай эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох олон улсын стандартад нийцсэн нөхцлийг бүрдүүлэх явдал мөн гэж эрүүл мэндийн байгууллагын зорилтыг тодорхойлсон байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчийн үүрэг гүйцэтгэнэ” гэж заасны дагуу Эрүүл мэнд, спортын сайд дээрх үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгосон байна. Мөн үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүждэг байна. Эрүүл мэнд, спортын яамны үйл ажиллагааны талаар (ТАБ-СТА-А-1) маягтад тодорхой тусгасан байна.

### **Материаллаг байдал**

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2015 оны жилийн эцсийн тайланд толилуулсан нийт зардлын 2.0 хувиар тооцож 10,514.9 сая төгрөгөөр тогтоов. Төлөвлөлтийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг алдаа илэрсэнгүй.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. (ТАБ-СТА-А-5)

Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах

аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлаггүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Эрүүл мэнд, спортын сайдын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

### **Дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн.

Эрүүл мэнд, спортын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “Дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт “Дунд” байна.

### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар**

Эрүүл мэнд, спортын яамны 2015 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг яамны Төрийн нарийн бичгийн даргаар хянуулж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжигдсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан байна.

Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар улсын төсвөөс урсгал зардалд 352,482.2 сая, хөрөнгийн зардалд 38,878.6 сая төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Урсгал санхүүжилтээс өндөр насны тэтгэвэр тэтгэмжийн зардал 3,077.7 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчидад төрөөс үзүүлэх дэмжлэг 1,172.8 сая төгрөг, спортын уралдааны тэмцээний зардал 420.0 сая төгрөгийг Төв төрийн сангаас дутуу санхүүжүүлжээ.

### **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд ([shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn)) вэб хуудсанд шилэн дансыг байршуулсан байна.

МУ-ын Засгийн газрын 2015 оны 9 дүгээр сарын 14-ны хуралдааны тэмдэглэлд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэт тайлагнаагүй Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргад албан тушаалын цалингийн хэмжээг 1 сарын хугацаагаар 20 хувь бууруулах шийтгэл ногдуулахыг сайд асан Г.Шийлэгдамбад үүрэг болгосон байна. Үүний дагуу ЭМСС /хуучнаар/-ын 2015 оны 398 дугаар тушаалын дагуу ТНБД асан Г.Ганчимэгт дээрх сахилгын шийтгэлийг ногдуулсан байна.

## **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар**

ЭМСС-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх төлөвлөгөөгөөр төлөвлөлтийн шатанд 6 дансанд эрсдэл байж болзошгүй гэж тогтоосны дагуу нарийвчилсан сорилын аргаар ажиглалт, тулган баталгаажуулах, харьцуулах зэрэг сорилуудыг хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатыг 10, гүйцэтгэлийн үе шатыг 9, тайлагналын үе шатыг 7 ажилбараар тус тус гүйцэтгэж СТАУС програмд оруулж, холбогдох албан тушаалтнуудаар хянууллаа.

Мөн үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, нотлох баримтуудыг тусгайлан ажлын баримтаар програмд орууллаа.

## **Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар**

ЭМСС-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, өр төлбөрийн дансны ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн шалгалаа.

## **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар**

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ЭМСС-ын шууд харьяа 24 байгууллага, Нийслэлийн эрүүл мэндийн харьяа 22 байгууллага, орон нутаг дахь Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын үндэсний төв, сум дундын эмнэлэг зэрэг 108 байгууллага, Тусгай зориулалтын шилжүүлгийн 44 байгууллага, 3 төсөл, хөтөлбөр, Төрийн өмчит аж ахуйн нэгжийн 5 нийт 206 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Үүнд: ЭМСС-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын 64.1 хувьд нь аудитад хамрагдсан байна. Нийт аудитад хамрагдсан байгууллагуудын 8.3 хувьд нь ҮАГ, 33.3 хувьд нь аймаг, нийслэлийн Аудитын газар, 22.5 хувьд нь хараат бус аудитын компани аудит хийж 97.4 хувьд нь “Зөрчилгүй”, 2.4 хувьд нь “Хязгаарлалттай”, 0.2 хувьд нь “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Тайлант онд ЭМСС-д 616,389.4 сая төгрөгийн төсөв батлагдсаны 8.3 хувьд нь ҮАГ, 33.3 хувьд нь аймаг, нийслэлийн Аудитын газар, 22.5 хувьд нь хараат бус аудитын компани, 10.2 хувьд нь түүвэрт хамрагдсан, 1.4 хувьд нь аудитын итгэл үзүүлсэн, 18.4 хувьд нь тусгай шилжүүлгийн байгууллагууд, үлдсэн 5.9 хувьд нь аудит хийгдээгүй байна.

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын дагуу “Монгол-Солонгосын Дорнын анагаах ухааны төв” Төрийн өмчит төсөвт албан газар, “Оргил рашаан сувилал” ТӨХК, “Био бэлдмэлийн үйлдвэр” ААТҮГ, “Булган аймгийн Хангал сумын спортын бэлтгэл сургалтын төв” УУААТГ, “Буянт ухаа спортын ордон” ААТҮГ гэх зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан ЭМСС-ын төсвийн багцын санхүүгийн тайланд нэгтгэгдэн тайлагнагдсан байна. Харин Техник спортын төв ТӨҮГ-ын статусыг шүүхээр шийдвэрлэх шатандаа явж байгаа тул тус байгууллагын санхүүгийн тайлан ЭМСС-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдээгүй болно.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна.Үүнд:

1.Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас 11 төсвийн шууд захирагч Булган аймгийн Хангал сумын спортын бэлтгэл сургалтын төв, Шим тэжээл, хоол судлалын үндэсний лаборатори, Хоол тэжээл, шим судлалын лаборатори, Хор судлалын лаборатори, Эмийн сорилтын лаборатори, Үндэсний оношлогоо, эмчилгээ болон Эрүүл мэндийн хөтөлбөр-IV,IV+,V төслүүд, Глобал сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа Сүрьеэгийн, ЭМ-ийн тогтолцоог бэхжүүлэх, ДОХ-ын төслийн санхүүгийн тайланг аудитад хамруулалгүй ЭМСС-ын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-ийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-ийн дагуу аудитад хамруулах арга хэмжээ авч байх талаар зөвлөмж өгөх.

2.Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч нь төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Үндэсний аудитын газарт 2016 оны 4 дүгээр сарын 05-нд 1а/1388 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Тус санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг нэгтгээгүй нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-д “...төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн тайлагналын зорилгоор хяналтанд байгаа төсөвт байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн санхүүгийн нэгтгэсэн тайланг толилуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч нь 2015 оны санхүүгийн нэгтгэсэн залруулсан тайланг 2016 оны 4 дүгээр сарын 21-ний 1а/1682 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт дахин ирүүлсэн. Тус санхүүгийн нэгтгэсэн залруулсан тайлан нь өмнөх хуулийн хугацаанд ирүүлсэн тайлангаас санхүүгийн байдлын тайлан нь нийт 64,072.8 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь материаллаг байдлын тогтоосон түвшингөөс 53,557.9 сая төгрөгөөр илүү байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийг мөрдөж ажиллах, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримтлан ажиллах талаар зөвлөмж өгөх.

3.Залруулсан санхүүгийн нэгтгэсэн тайланд гадаад зээлийн болон тусламжийн дансдын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн тодруулгад бүрэн тусгаагүй нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 4.2.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардлын зүйлсийг тохируулсны дараа нэгтгэсэн дүнг гарган тайлагнана”, мөн журмын 4.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын хооронд хийгдсэн устгагдсан ажил, гүйлгээг маягт 1-ийн 1.1, 1.2-ын дагуу баталгаажуулан санхүүгийн



тайланд хавсарган ирүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Засгийн газрын нөөц хөрөнгийн дүн, улсын төсвөөс авсан санхүүжилтийн буцаан төвлөрүүлэлтийн дүнг тус тус зөрүүтэй тайлагнасан нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт 1-ийн хавсралт А-д “Үнэн зөв”, “Иж бүрэн”, “Тохиолдсон байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримтлан ажиллах талаар зөвлөмж өгөх.

4.ЭМСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 39,262.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний 63.8 сая төгрөгийн зөрчилд 59 төлбөрийн акт, 1,420.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 39 албан шаардлага өгсөн бөгөөд аудитын явцад 13,306.9 сая төгрөгийн алдааг залруулж, 236.4 сая төгрөгийн зөрчилтэй холбогдуулан 11 албан тушаалтанд хариуцлага тооцох санал өгч, 29 төсөвт байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал, дүгнэлт өгсөн байна. Аудитын явцад 23,952.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар 235 зөвлөмж өгсөн байна. Энэ нь Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дээрх зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14.2.10-д “Төсвийн Ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “.....санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан.....албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн “Хязгаарлалттай” аудитын дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох, дотоод аудитыг сайжруулж, аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлэн ажиллах талаар зөвлөмж өгөх.

5.Хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүгийн аудитын явцад ЭМСС-ын 2015 оны 101 дүгээр тушаалын дагуу техник хяналтын 265.8 сая төгрөгийн зардлыг зарцуулах тушаалаар 74.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Тавилга, эд хогшлын зардалд 57.4 сая төгрөг, барилгын засварын тохижилтын зардалд 17.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Төсвийн тухай хуулийг мөрдөж хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

### **Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:**

1.Төсвийн ерөнхий нягтлан бодогч тайлант онд 3 удаа солигдсоноос шалтгаалан ЭМСС-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 3 удаа засагдаж 2016 оны 4 дүгээр сарын 21-нд залруулсан санхүүгийн тайланг ирүүлсэн. Энэ нь санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэхэд учир дутагдалтай байсан.

**Шийдвэрлэсэн:** Цаашид санхүүгийн багыг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.ЭМСС-ын төсвийн багцын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд УАГ-аас 7 зөвлөмж өгсөн боловч аудитын явцад зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд дахин зөрчил давтагдан гарч байгаа нь тус яамнаас харьяа байгууллагад тавих хяналт сул байгаатай холбоотой байна.

**Шийдвэрлэсэн:** Өмнөх санхүүгийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах талаар зөвлөмж өгөх.

### **Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Аудитын явцад нийт 13,306.9 сая төгрөгийн ажил гүйлгээг стандартын дагуу залруулж, 90,103.6 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

### **Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

ЭМСС-ын төсвийн багцын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд санхүүгийн ажилтнууд солигдсноос аудит хийхэд хүндрэл учруулж байлаа.

### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

ЭМСС-ын төсвийн багцын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй асуудал нь тус сайдын харьяа байгууллагуудын Арилжааны банкин дах төгрөг болон валютын дансны зөвшөөрлийг цаг хугацаа богино байгаагаас нэг бүрчлэн хянах боломжгүй байлаа.

### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

ЭМСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 39,262.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний 63.8 сая төгрөгийн зөрчилд 59 төлбөрийн акт, 1,420.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 39 албан шаардлага өгсөн бөгөөд аудитын явцад 13,306.9 сая төгрөгийн алдааг залруулж, 236.4 сая төгрөгийн зөрчилтэй холбогдуулан 11 албан тушаалтанд хариуцлага тооцох санал өгч, 29 төсөвт байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал, дүгнэлт өгсөн байна. Аудитын явцад 23,952.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар 235 зөвлөмж өгсөн байна.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

ЭМСС-ын төсвийн багцын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд УАГ-аас 7 зөвлөмж өгсөн боловч аудитын явцад зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлээгүйгээс биелэлтийг тооцох боломжгүй байлаа.

### **Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээрх дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Эрүүл мэнд, спортын сайдын төсвийн багцын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай

Эрүүл мэнд, спортын яамны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу  
материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.

## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

### **Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:**

#### **Асуудал 1**

Санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### **Асуудал 2**

Санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### **Асуудал 3**

Санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### **Асуудал 4**

Санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### **Асуудал 5**

Хөрөнгө оруулалт

#### **Асуудал 6**

Боловсон хүчин

#### **Асуудал 7**

Зөвлөмжийн биелэлт

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Эрүүл мэнд, спортын яамны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ЭМСЯ-ны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АСУУДАЛ 1: САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

### ***ҮАГ-ын ажиглалт***

Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас 11 төсвийн шууд захирагч Булган аймгийн Хангал сумын спортын бэлтгэл сургалтын төв, Шим тэжээл, хоол судлалын үндэсний лаборатори, Хоол тэжээл, шим судлалын лаборатори, Хор судлалын лаборатори, Эмийн сорилтын лаборатори, Үндэсний оношлогоо, эмчилгээ болон Эрүүл мэндийн хөтөлбөр-IV,IV+,V төслүүд, Глобал сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа Сүрьеэгийн, ЭМ-ийн тогтолцоог бэхжүүлэх, ДОХ-ын төслийн санхүүгийн тайланг аудитад хамруулалгүй ЭМСС-ын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-ийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### ***ҮАГ-ын зөвлөмж***

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-ийн дагуу аудитад хамруулах арга хэмжээ авч байх.

### ***Эрсдэлүүд***

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан нэгтгэгдээгүйгээс санхүүгийн тайлангийн дүгнэлтэд нөлөөлөх;

### ***Төсвийн захирагчийн хариу***

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

## АСУУДАЛ 2: САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

### *ҮАГ-ын ажиглалт*

Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч нь төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Үндэсний аудитын газарт 2016 оны 4 дүгээр сарын 05-нд 1а/1388 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Тус санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг нэгтгээгүй нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-д “...төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн тайлагналын зорилгоор хяналтанд байгаа төсөвт байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн санхүүгийн нэгтгэсэн тайланг толилуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч нь 2015 оны санхүүгийн нэгтгэсэн залруулсан тайланг 2016 оны 4 дүгээр сарын 21-ний 1а/1682 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт дахин ирүүлсэн. Тус санхүүгийн нэгтгэсэн залруулсан тайлан нь өмнөх хуулийн хугацаанд ирүүлсэн тайлангаас санхүүгийн байдлын тайлан нь нийт 64,072.8 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь материаллаг байдлын тогтоосон түвшингөөс 53,557.9 сая төгрөгөөр илүү байна.

### *Эрсдэлүүд*

Хуулийн хугацаанд санхүүгийн тайлан гарахгүй байснаар хугацаандаа аудит хийгдэхгүй байх;

### *ҮАГ-ын зөвлөмж*

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл болон Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримтлан ажиллах.

### *Төсвийн захирагчийн хариу*

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

### АСУУДАЛ 3: САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

#### **ҮАГ-ын ажиглалт**

Залруулсан санхүүгийн нэгтгэсэн тайланд гадаад зээлийн болон тусламжийн дансдын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн тодруулгад бүрэн тусгаагүй нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 4.2.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардлын зүйлсийг тохируулсны дараа нэгтгэсэн дүнг гарган тайлагнана”, мөн журмын 4.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын хооронд хийгдсэн устгагдсан ажил, гүйлгээг маягт 1-ийн 1.1, 1.2-ын дагуу баталгаажуулан санхүүгийн тайланд хавсарган ирүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Засгийн газрын нөөц хөрөнгийн дүн, улсын төсвөөс авсан санхүүжилтийн буцаан төвлөрүүлэлтийн дүнг тус тус зөрүүтэй тайлагнасан нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт 1-ийн хавсралт А-д “Үнэн зөв”, “Иж бүрэн”, “Тохиолдсон байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Эрсдэлүүд**

Хууль, дүрэм журмын дагуу санхүүгийн тайлан бэлтгэгдээгүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

#### **ҮАГ-ын зөвлөмж**

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг баримтлан ажиллах.

#### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



**АСУУДАЛ 4: САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН  
ТАЙЛАН**

**ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1**

***ҮАГ-ын ажиглалт***

ЭМСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 39,262.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний 63.8 сая төгрөгийн зөрчилд 59 төлбөрийн акт, 1,420.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 39 албан шаардлага өгсөн бөгөөд аудитын явцад 13,306.9 сая төгрөгийн алдааг залруулж, 236.4 сая төгрөгийн зөрчилтэй холбогдуулан 11 албан тушаалтанд хариуцлага тооцох санал өгч, 29 төсөвт байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал, дүгнэлт өгсөн байна. Аудитын явцад 23,952.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар 235 зөвлөмж өгсөн байна. Энэ нь Эрүүл мэнд, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дээрх зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14.2.10-д “Төсвийн Ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

***Эрсдэлүүд***

Санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчил ихэссэнээс санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх.

***ҮАГ-ын зөвлөмж***

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “.....санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан.....албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн “Хязгаарлалттай” аудитын дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох, дотоод аудитыг сайжруулж, аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлэн ажиллах;

***Төсвийн захирагчийн хариу***

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

## АСУУДАЛ 5: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

## ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

### ***ҮАГ-ын ажиглалт***

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүгийн аудитын явцад ЭМСС-ын 2015 оны 101 дүгээр тушаалын дагуу техник хяналтын 265.8 сая төгрөгийн зардлыг зарцуулах тушаалаар 74.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Тавилга, эд хогшлын зардалд 57.4 сая төгрөг, барилгын засварын тохижилтын зардалд 17.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### ***Эрсдэлүүд***

Зориулалтын хөрөнгийг ашиглаагүйгээс хөрөнгө үргүйдэх;

### ***ҮАГ-ын зөвлөмж***

Төсвийн тухай хуулийг мөрдөж хэрэгжүүлж ажиллах;

### ***Төсвийн захирагчийн хариу***

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

## АСУУДАЛ 6: БОЛОВСОН ХҮЧИН

## ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

### ***ҮАГ-ын ажиглалт***

Төсвийн ерөнхий нягтлан бодогч тайлант онд 3 удаа солигдсоноос шалтгаалан ЭМСС-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 3 удаа засагдаж 2016 оны 4 дүгээр сарын 21-нд залруулсан санхүүгийн тайланг ирүүлсэн. Энэ нь санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэхэд учир дутагдалтай байсан.

### ***Эрсдэлүүд***

Санхүүгийн ажилтануудын тогтвор суурьшил муу байгаагаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

### ***ҮАГ-ын зөвлөмж***

Цаашид санхүүгийн багыг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч ажиллах.

### ***Төсвийн захирагчийн хариу***

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

## АСУУДАЛ 7: ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

## ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

### **ҮАГ-ын ажиглалт**

ЭМСС-ын төсвийн багцын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас 7 зөвлөмж өгсөн боловч аудитын явцад зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд дахин зөрчил давтагдан гарч байгаа нь тус яамнаас харьяа байгууллагад тавих хяналт сул байгаатай холбоотой байна.

### **Эрсдэлүүд**

Зөвлөмж биелүүлээгүйгээс санхүүгийн тайлангийн зөрчил буурахгүй байх;

### **ҮАГ-ын зөвлөмж**

Өмнөх санхүүгийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>49,547,909,397.12</b>	<b>47,842,769,856.23</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>9,551,974,879.20</b>	<b>8,617,806,197.74</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>278,977,845.29</b>	<b>16,528,131.22</b>
31110	Төгрөг	185,771,165.29	16,528,131.22
31120	Гадаад валют		
31130	Нэмэлт санхүүжилт	93,206,680.00	
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>9,272,997,033.91</b>	<b>8,601,278,066.52</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>5,326,097,467.02</b>	<b>2,562,895,175.20</b>
31211	Төрийн сангийн харилцах	4,807,549,875.05	2,438,564,445.03
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах	5,670,626.60	7,447,933.17
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	512,876,965.37	116,882,797.00
<b>31220</b>	<b>Гадаад валют</b>	<b>3,946,899,566.89</b>	<b>6,038,382,891.32</b>
31222	Монгол банк дахь харилцах		
31223	Арилжааны банк дахь харилцах	3,946,899,566.89	6,038,382,891.32
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,253,941,894.96</b>	<b>1,593,330,662.24</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	23,589,320.96	35,619,589.60
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	140,121,067.90	105,065,163.79
33300	Татаас, санхүүжилтийн авлага	313,072,239.45	359,886,510.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		464,838.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>2,777,159,266.65</b>	<b>505,921,884.89</b>
33510	Байгууллагаас авах авлага	2,687,776,747.82	430,774,253.70
33520	Хувь хүмүүсээс авах авлага	89,382,518.83	75,147,631.19
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>-</b>	<b>586,372,675.96</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>-</b>	<b>586,372,675.96</b>
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		586,372,675.96
